



[/БОНХС-ын 2013 оны А-250-р тушаалаар хүчингүй болсон/](#)

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ АХУЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР 2012 ОНД АГНАХ, БАРИХ АГНУУРЫН АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ 2012 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улаанбаатар хот Дугаар А-05 “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, “Ан агнуурын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь: 1.Ахуйн зориулалтаар 2012 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг 1 дүгээр, үйлдвэрлэлийн зориулалтаар 2012 онд барих агнуурын загасны тоо хэмжээний дээд хязгаарыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай. 2.Энэхүү тушаалыг 2012 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/, Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт даалгасугай. САЙД Л. ГАНСҮХ Улсын бүртгэлд 2012 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 3304 дүгээрт бүртгэсэн.